

“МОНОС ХҮНС” ХК-ИЙН 2022 ОНД НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

1. СХД-ийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран томуугийн халдвараас сэргийлэх өдөрлөгийг зохион байгуулав



Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлгийн Нийгмийн эрүүл мэнд, хамтын ажиллагааны албанаас санаачлан Монос Хүнс ХК-ийн дэмжлэгтэйгээр томуугийн халдвараас сэргийлэх өдөрлөгийг энэ сарын 25-ний өдөр амжилттай зохион байгууллаа.

Тус арга хэмжээний үеэр Монос Хүнс компани Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй 600 орчим хүүхэд, асран хамгаалагчид дархлаа дэмжих нэрийн бүтээгдэхүүнийг гардуулан өгч, жүжигчилсэн тоглолт үзүүллээ. Мөн энэ үеэр СХНЭ-ийн эмч, мэргэжилтнүүд хэвтэн эмчлүүлэгчдэд гараа хэрхэн зөв угааж халдварт өвчнөөс хэрхэн сэргийлэх талаар зөвлөмж, зөвлөгөөг хүүхэд багачууддаа сонирхолтой хэлбэрээр өгсөн юм.

Холбогдох линк: <https://cutt.ly/BMoxiyM>

2. “Маамуутай нэг өдрийг хамтдаа” өдөрлөгийг зохион байгууллаа



Эрүүл мэндийг дэмжигч Монос Хүнс ХК 10 жилийн ойн хүрээнд Монгол контент ХХК-тай хамтран “Ид шидийн орон 2” хүүхэд хамгааллын төвд “Маамуутай нэг өдрийг хамтдаа” өдөрлөгийг зохион байгуулав. Энэ үеэр 200 гаруй хүүхэд гарын бэлэг гардуулж, Аами&Таами хүүхдүүдийн хамт нэг өдрийг хөгжилтэй өнгөрүүллээ.

Манай компани эх хүүхдийн эрүүл мэнд болон нийгмийн асуудалд чиглэсэн төсөл хөтөлбөрийг тогтмол санаачлан, холбогдох байгууллагуудтай хамтран ажилладаг. Тухайлбал, 2015 оноос эхлэн “Ид шидийн уут” аянд Аз жаргалын амттай- BerryVit брэнд нэгдсэн бөгөөд хүүхэд багачуудад чиглэсэн эрүүл мэндийн сургалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна.

Холбогдох линк: <https://cutt.ly/uMoxcCu>

3. “Эрүүл мэндийн өдөрлөг, арга хэмжээ” зохион байгуулагдаж эхэллээ



Монос Хүнс ХК уламжлал болгон зохион байгуулдаг бүтээгдэхүүний танилцуулга, эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэл өгөх зорилготой “Эрүүл мэндийн өдөрлөг, арга хэмжээ”-гээ энэ жил Өвөржанчивлан рашаан сувиллаар эхлүүлж байна.

Тус арга хэмжээнд 180 гаруй амрагч, ажилтан хамрагдсан бөгөөд нийгэмд тулгамдаад буй өвчлөл, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар эмч, мэргэжилтнүүд эрүүл мэндийн зөвлөгөө өглөө.

Холбогдох линк: <https://cutt.ly/UMocDdC>

4. Дархлаа түгээе- Эрүүл амьдралын хэв маяг өдөрлөг



“Дархлаа түгээе” уриан дор эрүүл амьдралын хэв маяг өдөрлөг зохион байгууллаа. Тус өдөрлөгт Монос Хүнс ХК эрүүл мэндийн БИО энергийн аппаратаар үзлэг оношилгоо үнэ төлбөргүй хийж, хүүхэд багачуудын дуртай Аами, Таами, Жожо болон “Vitos” брэндийн Шот бүтээгдэхүүнүүдийн тус тус амталгаат худалдаа болсон юм. Мөн Аами&Таами баатрууд нь хүрэлцэн ирж хүүхэд багачууд, найз нөхөдтэйгөө нэг өдрийг хөгжилтэй өнгөрүүлээ.

Холбогдох линк: <https://cutt.ly/DMovbng>

5. “Эрдэнэт хүн таны эрүүл биеийн төлөө” сувилал өдөрлөг



Эрүүл мэндийг дэмжигч Монос Хүнс ХК-аас нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүр ахмадууддаа чиглэсэн ажлууд зохион байгуулдаг бөгөөд энэ жил “Эрдэнэт хүн таны эрүүл биеийн төлөө” уриан дор Өвөржанчивлан рашаан сувиллаар эхлүүлсэн. 2022.06.15-ны өдөр

ээлжит сургалт өдөрлөгөө Аржанчивлан болон Задгай цагаан рашаан сувиллуудаар амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээнд нийт 170 гаруй амрагч, ажилтан хамрагдсан бөгөөд нийгэмд тулгамдаад буй өвчлөл, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар эмч, мэргэжилтнүүд эрүүл мэндийн зөвлөгөө өглөө. Мөн сургалтын үеэр Энхжин брэндийн эрүүл мэндийн цай болон VITOS | SHOT биологийн идэвхт бүтээгдэхүүнүүдийг танилцуулж, сургалтад хамрагдсан хүмүүст гарын бэлэг өгсөн юм.

Холбогдох линк: <https://cutt.ly/IMov6lW>

6. Дэлхийн Гепатитын өдөрт зориулсан сургалт зохион байгуулав



Дэлхий нийтээр жил бүрийн 07-р сарын 28-ний өдрийг Дэлхийн гепатитын өдөр буюу Элэгний үрэвслийн талаар мэдлэгийг дээшлүүлэх өдөр болгон тэмдэглэж ирсэн.

Монос Хүнс ХК жил бүр тус өдрийг тохиолдуулан эрүүл мэндийн байгууллагатай хамтран элэгний өвчлөлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх, элэгний өвчлөлд гол хүчин нөлөөлдөг шалтгааны талаар таниулах, мэдээлэх зорилгоор сургалтууд зохион байгуулдаг билээ. Энэ жил Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран “Элэгний хорт хавдар, түүнээс урьдчилан сэргийлэлт” сэдвийн хүрээнд эмнэлгээр үйлчлүүлж байсан иргэд, эмнэлгийн ажилтнуудыг хамарсан сургалтыг амжилттай болж өндөрлөлөө.

Холбогдох линк: <https://cutt.ly/RMobD3D>

7. ЭХЭМҮТ-ийн Ерөнхий мэс заслын тасгийн өрөөг сэргээн засварлаж, тохижууллаа.



Монос Хүнс Хувьцаат компанийн санаачилгаар ЭХЭМҮТ-ийн Ерөнхий мэс заслын тасгийн хүлээлгийн болон үзлэгийн өрөөг иж бүрэн тохижуулж өнөөдөр хүлээлгэн өглөө.

Энэхүү 2 өрөө нь жилдээ 13,000 гаруй хүүхэд өөрийн асран хамгаалагчийнхаа хамт төлөвлөгөөт болон яаралтай мэс заслын өмнөх мэдээгүйжүүлэлтийн үзлэг, эмч нарын зөвлөгөөг авч хүнд болон хөнгөн хагалгааны өмнө аав, ээж асран хамгаалагчийн хамт сэтгэл санаагаа бэлдэх, цагийг өнгөрүүлэх зорилготой өрөө юм.

Холбогдох линк: <https://cutt.ly/rMontYf>

8. Каннын кино наадамд Монгол Улсаас анх удаа оролцож буй хүүхдийн киног ивээн тэтгэлээ



Дэлхийн кино урлагийн салбарын тэргүүн зэрэглэлийн Каннын кино наадам энэ жил 75 дахь удаагаа зохион байгуулагдаж байна.

Тус кино наадамд “Том толгойтын адал явдлууд” киноны уран бүтээлчид Марше ду фильм арилжааны хэсэгт хүүхдийн киногоор Монгол Улсаас анх удаа оролцож, Монос Хүнс ХК ивээн тэтгэж хамтран ажиллаа. Кино урлагийн салбарт цоо шинэ хувьсал хийж эх орныхоо нэрийг дэлхийн тавцанд гаргаж байгаа уран бүтээлчиддээ амжилт хүсье.

Монголын кино урлаг өндөр түвшинд хөгжиж, дэлхийд гарах болтугай!

Холбогдох линк: <https://cutt.ly/HMonU2D>

9. Ширээний теннисний өсвөр үеийн УАШТ-ийг ивээн тэтгэлээ



Ширээний теннисний өсвөр үеийн улсын аварга шалгаруулах 54 дэх удаагийн тэмцээнийг Эрүүл амьдралын ус Экос брэнд ивээн тэтгэн оролцлоо. Тус тэмцээн нь энэ сарын сарын 05-07-ны өдрүүдэд дөрвөн бүс болон 9 дүүргийн 21 клуб, байгууллагын тамирчид ганцаарчилсан болон холимог төрлөөр зохион байгуулагдаж шилдгүүдээ шалгаруулсан юм.

Холбогдох линк: <https://cutt.ly/tMomtFZ>

10. Тамхины эсрэг өдрийн сургалт зохион байгуулав



Дэлхий дахинаа жил бүрийн 05-р сарын 31-ний өдрийг "Тамхины эсрэг өдөр" болгон тэмдэглэж тамхины утаа болон хэрэглээнээс үүдэлтэй уршгийг таниулах, эдийн засагт үзүүлэх хор нөлөөллийн мэдээллийг түгээх зорилгоор тэмдэглэдэг.

Монос Хүнс ХК жил бүр эрүүл мэндийн байгууллагатай хамтран энэхүү өдрийг таниулах, тамхины зохисгүй хэрэглээг бууруулах зорилгоор иргэдэд сургалт, мэдээлэл хүргэдэг билээ. Энэ жил Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран "Тамхины хор уршиг" сэдвийн хүрээнд иргэдэд сургалт хийлээ. Сургалтаар тамхины хэрэглээ, утаанаас үүдэлтэй хор хөнөөл болон тамхинаас ялгардаг бодисын хор хөнөөлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө мэдээллийг хүргэв. Мөн Энхжин брэндийн Уушги цэвэрлэх цайны талаар нийт эмч, сувилагч нарт мэдээлэл өглөө. Монос хүнс ХК болон СХД-ийн нэгдсэн эмнэлэг цаашид Тамхины эсрэг ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөн, хамтран ажиллаж эхлээд байна.

Холбогдох линк: <https://cutt.ly/aMomWoO>

11. "ЗҮРХЭЭ ХАЙРЛАЯ" өдөрлөг зохион байгуулав



Эрүүл мэндийг дэмжигч Монос Хүнс ХК-ийн зүгээс нийгэмд тулгамдаад буй өвчлөлийг бууруулахад дэм болох үүднээс жил бүр тухайлсан сургалт арга хэмжээг зохион байгуулдаг. Энэ жилийн арга хэмжээгээ "Зүрхээ хайрлая" нэрийн дор СХНЭ-ийн Хүний их эмч Э.Өнөржаргалтай хамтран 2022.06.02-ны өдөр иргэдийг хамран зохион байгууллаа.

Учир нь зүрх судасны тогтолцооны өвчин нь нийт өвчлөлийн 11.1%, нийт нас баралтын шалтгааны 1/3-ыг эзэлж байна.

Тус өдөрлөгөөр өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болсон зүрх судасны өвчлөлийн эрсдэлт хүчин зүйл болон түүнээс урьдчилан сэргийлэх арга замын талаар эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлэв.

Холестерин бууруулж, зүрх судасны үйл ажиллагааг дэмжих үйлдэлтэй VITOS | SHOT брэндийн Хар саримс бүтээгдэхүүнээ танилцуулж, үйл ажиллагаанд оролцсон хүмүүст гарын бэлэг өглөө. Мөн эхний бүртгүүлсэн иргэдийг био энергийн аппаратаар үнэ төлбөргүй оношиллоо.

Сайхан бүхний эхлэл болсон "ЗҮРХЭЭ ХАЙРЛАЯ"

Холбогдох линк: <https://cutt.ly/jMomB3z>